



МОНГОЛ УЛСЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМНЫ ДЭРГЭДЭХ
ЭМНЭЛГИЙН МЭРГЭЖИЛТНИЙ ЁС ЗҮЙН ХЯНАЛТЫН
ХОРООНЫ ТОГТООЛ

2026 оны 03 сарын 02 өдөр

Дугаар 02

Улаанбаатар хот

Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн
салбар хорооны бүрэлдэхүүнийг
шинэчлэн батлах тухай

Эрүүл мэндийн тухай хуулийн 26.1, Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хяналтын хорооны дүрмийн 3.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Геронтлогийн үндэсний төвийн дэргэдэх Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн салбар хорооны бүрэлдэхүүнийг хавсралтаар баталж, 2026 оны 03 дугаар сарын 02-ны өдрөөс эхлэн 3 жилийн хугацаатай томилон ажиллуулсугай.

2. Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн алдаа, зөрчлөөс сэргийлж, соён гэгээрүүлэх ажлыг тогтмол хийх, өргөдөл гомдлыг хууль эрх зүйн хүрээнд шуурхай шийдвэрлэх, салбар хорооны үйл ажиллагааны төлөвлөгөө, тайланг Эрүүл мэндийн яамны дэргэдэх Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хяналтын хороонд хугацаандаа ирүүлж байхыг салбар хороо (Э.Наранхүү)-нд даалгасугай.

3. Салбар хорооны бүрэлдэхүүнийг мэдээний санд бүртгэх, тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хяналтын хорооны нарийн бичгийн даргад үүрэг болгосугай.

4. Энэхүү тогтоол батлагдсантай холбогдуулан 2023 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн 29 дүгээр тогтоолыг хүчингүйд тооцсугай.

ДАРГА



Д.ОЮУНБИЛЭГ

147260161

Эрүүл мэндийн яамны дэргэдэх Эмнэлгийн
мэргэжилтний ёс зүйн хяналтын хорооны 2026
оны 03 дугаар сарын 02-ны өдрийн 02 дугаар
тогтоолын хавсралт



ГЕРОНТОЛОГИЙН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ДЭРГЭДЭХ
ЭМНЭЛГИЙН МЭРГЭЖИЛТНИЙ ЁС ЗҮЙН САЛБАР ХОРООНЫ БҮРЭЛДЭХҮҮН

Ёс зүйн салбар хорооны дарга: Э.Наранхүү, Геронтологийн үндэсний төвийн Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлын албаны дарга

Ёс зүйн салбар хорооны орлогч дарга: О.Очгэрэл, Геронтологийн үндэсний төвийн сэргээн засал судлалын их эмч

Нарийн бичгийн дарга: Ч.Өнөрцэцэг, Геронтологийн үндэсний төвийн Хүний нөөцийн менежер

Гишүүд: Э.Солонго, Геронтологийн үндэсний төвийн Нийгмийн эрүүл мэнд, ахмад настны сургалт хариуцсан мэргэжилтэн

Ц.Мандахзаяа, “Сэтгэл зүйн боловсролын төв” төрийн бус байгууллагын захирал